



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 5 дугаар сарын 27 өдөр

Дугаар А-109

Улаанбаатар хот

Зарим цэцэрлэг, сургуулиудад бүтцийн өөрчлөлт хийх тухай

Нэг. Гэгээрлийн яамнаас "Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхээр гаргасан зөвлөмжийн дагуу зарим сургууль, цэцэрлэгээс ирүүлсэн төсөл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын тооцоо, саналыг хэлэлцэн нийслэлийн ажлын хэсгээс гаргасан дүгнэлтийг үндэслэн зарим сургууль, цэцэрлэгүүдийн бүтцийн өөрчлөлтийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Бүтцийн өөрчлөлтийн хоёр дахь шатны үйл ажиллагааг 1998 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (н.Мөнхжаргал), Боловсролын газрын дарга (н.Дорж), дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

Гурав. Шинээр зохион байгуулагдах сургууль, цэцэрлэгийн цогцолборуудын захирал эрхлэгчдийг томилохдоо тусгай хөтөлбөр, төслийг нь сонгон шалгаруулах замаар шийдвэрлүүлэхийг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (н.Хадхүү), Боловсролын газрын дарга (н.Дорж), дүүргүүдийн Засаг дарга нарт даалгасугай.



[Signature] Ж.НАРАНЦАЦРАЛТ

Нийслэлийн Засаг даргынх 1998 оны
4-109 тоот захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАРИМ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮ-
ДЭД ХИЙХ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ

Нэг. Сонгинохайрхан дүүрэгт

- 110 дугаар цэцэрлэгийг 6-7 настай хүүхдүүд авч сургах цэцэрлэг
- 127 дугаар цэцэрлэгийг бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор
- 163 дугаар цэцэрлэгийг бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор болгох

Хоёр. Баянгол дүүрэгт

- 38, 20 дугаар сургуулийг нэгтгэж цогцолбор болгох
- 43, 56 дугаар сургуулийг нэгтгэж цогцолбор болгох.
- 70 дугаар сургуульд хэл заслын салбар төв нээн хичээллүүлэх.
- 46 дугаар сургуулийг сургалт үйлдвэрлэлийн "Сэтгэмж" цогцолбор болгох.

Гурав. Чингэлтэй дүүрэгт

- 19 дүгээр цэцэрлэг, 24 дүгээр сургуулийг "Мөнхтэнгэр" цогцолбор болгох.
- 5 дугаар цэцэрлэгийг сургуулийн өмнөх насны хүүхдийг сургуульд бэлтгэх төв болгох.
- 61 дүгээр сургууль, 57 дугаар сургуулийг цогцолбор болгох.

Дөрөв. Баянзүрх дүүрэг

- 8 дугаар сургууль, 27 дугаар сургуулийг цогцолбор болгох.
- 52, 146 дугаар цэцэрлэгүүдийг нэгтгэж цогцолбор болгох.
- 8 дугаар цэцэрлэгийг оюун ухааны хомсдолтой хүүхдийг ердийн нөхцөлд хүмүүжүүлэх цэцэрлэг болгох.

Тав. Багануур дүүрэгт

- 64, 69, 95 дугаар сургуулиудыг нэгтгэн ахлах, дунд, бага сургуультай цогцолбор болгох.
- Боловсрол төвийг цаашид ажиллуулах.

Зургаа. Хан-уул дүүрэгт

- 18 дугаар сургуулийг 41 дүгээр цэцэрлэгтэй сургууль, цэцэрлэгийн цогцолбор болгох.
- 72 дугаар цэцэрлэг, 75 дугаар сургуулийг цогцолбор болгож Орхон дээд сургуультай гэрээтэй ажиллуулах.
- 15 дугаар сургууль, 46 дугаар цэцэрлэгийг цогцолбор болгож Хан-уул дээд сургуультай гэрээтэй ажиллуулах.
- 29, 71 дүгээр цэцэрлэгүүдийг нэгтгэж удирдлагын бүтцийг өөрчлөх.

Долоо. Налайх дүүрэгт

- 99, 100, 101, 103 дугаар сургууль, Тэрэлжийн бага сургуулийг нэгтгэж цогцолбор болгох.